



НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/177 дугаар захирамжаар батлагдсан “Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/250 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам”, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар” зэргийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баримт бичгийг нягтлан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

№	Комиссын бүрэлдэхүүн	Албан тушаал	Овог нэр
1	Комиссын дарга:	Цахилгааны инженер	Д.Мөнхбаяр
2	Комиссын гишүүд:	Зохион байгуулагч Албаны дарга Ахлах нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч Хүний нөөцийн ажилтан Лифтчин	Д.Цогжаргал Ж.Дуламжав Ө.Цолмон Ц.Пүрэвсүрэн П.Сэрсмаа Л.Болорчимэг
3	Нарийн бичгийн дарга	Эд хариуцагч	Б.Баярчимэг

2. Комисст байгууллагын баримт бичгийг нягтлан шалгах ажиллагааны батлагдсан дүрмийг хэрэгжүүлж ажиллахыг даалгасугай.
3. Комиссыг Нийслэлийн Архивын газраас арга зүйн зөвлөгөө авч, хамтран ажиллахыг зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Б.БАЙГАЛМАА

